



БНСУ-аас 2018 онд мэргэжлийн бус ажил эрхлэх гадаадын иргэдэд олгодог “Е-9” ангиллын визийг 56 мянган хvнд олгоно хэмээн “Naver.com” сайт дээр мэдээлжээ. “Е-9” ангиллын визээр Омнод Солонгос улсад ходолмор эрхлэх иргэд

- Үйлдвэрлэлийн салбарт 42 300,
- Ходоо аж ахуйн салбарт 6 600,
- Загас агнуурын салбарт 2 600,
- Барилгын салбарт 2 400,
- Үйлчилгээний салбарт 1 100 гэсэн квоттой ажлын байр зарласан байна.

“Е-9” ангиллын визтэй иргэд БНСУ-аас 8 сараас 9 жил (4 жил 10 сар+4 жил 10 сар) хvртэл хугацаагаар ажиллаж, амьдрах боломжтой байдаг юм.

Одоогийн байдлаар 7500 гадаадын иргэн визийн эцсийн хугацаа болох есон жилээ дуустал ажиллахаа БНСУ-ын албаныханд мэдэгджээ. Тус улсын Цагдаагийн албанаас хууль бусаар ходолмор эрхэлж буй иргэдийг нутаг буцаах арга хэмжээгээ эрчимжvллнэ

гэдгээ мон мэдэгдсэн байна.